




ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН НЭГДСЭН УДИРДАМЖААР ХИЙГДСЭН
“ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ” СЭДЭВТ НИЙЦЛИЙН АУДИТ



Хуулийн үйчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансанд
байршуулах мэдээллийг мэдээлэх, тайлагнах үйл
ажиллагаа хангалтгүй байна

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн Үндэсний аудитын газрын харъяа Дорноговь аймгийн Төрийн Аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа Аудитын менежер Ч.Хэрлэнчимэг Ахлах аудитор Л.Аваадорж Аудитор Т.Ган-Өлзий Аудитор Б.Тунгалагтуяа Аудитор О.Нарангарав Аудитор У.Оюунтүлхүүр 2017 оны 11 дүгээр сарын 16 Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах асууж лавлах зүйл байвал 70523020 дугаарын утас 70522734 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Дорноговь аймаг Сайншанд сумын 3-р баг Орон нутгийн өмчийн 3 дугаар байр	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй БҮЛЭГ 1: Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд шилэн дансны системд бүрэн хамрагдсан байна. 1.1 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т зааснаас бусад байгууллагууд шилэн дансны нэгдсэн системд хамрагдсан байна. 1.2 Зарим байгууллагуудын шилэн дансны мэдээлэл хүргэх цэс хууль, журамд заасан шалгуурыг хангаагүй харилцан адилгүй байна. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллага тус аймагт үйл ажиллагаагаа явуулдаггүй байна. БҮЛЭГ 2: Төсөвт байгууллагууд шилэн дансны мэдээллийг байршуулж хэвшсэн ч төсвийн хөрөнгөөр ТАХ-г гүйцэтгэгч компаниуд уг ажлыг орхигдуулж байна. 2.1 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны системд мэдээллийг тогтмол байршуулахгүй байх зөрчил гарсаар байна. 2.2 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд 7 хоногийн дотор мэдээлэх мэдээллийн 71.5 хувийг хугацаанд нь мэдээлжээ. 2.5 Төсвийн хөрөнгөөр ТАХ-г гүйцэтгэгч хуулийн этгээд шилэн дансны цахим системд мэдээлэл байршуулах ажлыг огт хийгээгүй байна. БҮЛЭГ 3: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцоогүй байна. 3.1 Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурал хуулиар олгогдсон хөндлөнгийн хяналтын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. 3.2 Аймгийн ТЕЗ хуульд заасны дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан боловч алдаа зөрчил гаргасан албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллаагүй байна. 3.3 Байгууллага, албан тушаалтны үр дүнгийн гэрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тусгаж, дүгнэж ажилласан байна. 3.4 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд үндэслэн иргэдийн хяналтыг тодорхойлох боломжгүй байна.
---	---

	БҮЛЭГ 4: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна. 4.1 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн биелэгдсэн боловч мэдээллийг байршуулахгүй байх алдаа зөрчил давтагдсаар байна. 4.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна. Аудитын дүгнэлт Холбогдох байгууллагын санал Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар Аудитын зөвлөмж
--	--

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ДГА	Дорноговь аймаг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТАХ	Төсөл арга хэмжээ
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ААНБ	Аж ахуй нэгж, байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХААлба	Санхүүгийн хяналт, аудитын алба

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд аудит хийнэ.

Аудитын зорилт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараахь дэд зорилтын дагуу аудит хийлээ.

- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталсан эсэх
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудыг шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамрах хүрээ:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хуулийн этгээдийг хамруулан, хуульд заасан мэдээллийг 2016 оны 10 сарын 01-ний өдрөөс 2017 оны 10 сарын 01-ний өдрийнх хүртэлх хугацааны шилэн дансны нэгдсэн системд мэдээлсэн байдалд аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын 4000-4200 стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын аргазүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг аргазүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт гаргалаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль эрхийн актуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Аудитын хугацаа, бүрэлдэхүүн:

Аудитыг 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа хянан удирдаж, аудитын менежер Ч.Хэрлэнчимэг үе шатны хяналтыг гүйцэтгэж, нийцлийн аудитын албаны аудитор Т.Ган-Өлзий, санхүүгийн аудитын албаны ахлах аудитор Л.Аваадорж, аудитор Б.Тунгалагтуяа, О.Нарангарав, У.Оюунтүлхүүр нар гүйцэтгэв.

БҮЛЭГ 1

Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд шилэн дансны системд бүрэн хамрагдсан байна.

1.1 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т зааснаас бусад байгууллагууд шилэн дансны нэгдсэн системд хамрагдсан байна.

Дорноговь аймагт шилэн дансны нэгдсэн системд бүртгэлтэй төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 182, төрийн өмчит үйлдвэрийн газар дөрөв, хуулийн 3.1.5¹-д заасан үйлчилгээ үзүүлэгч нийт 11 (хувийн сургууль нэг, цэцэрлэг дөрөв, өрхийн эрүүл мэндийн төв тав, бусад нэг) байгууллага байна. Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т¹ заасан байгууллага тус аймагт байхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.5-д¹ заасны дагуу шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах байгууллагуудыг дараах байдлаар ангилж бүртгэсэн байна.

Шилэн дансны цахим хуудсанд
бүртгэлтэй байгууллагын тоо

№	Хамрагдах байгууллагын ангилал	Хамрагдвал зохих тоо	Цахим хуудсанд бүртгэлтэй байгууллагын тоо	Зөрүү
1	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд	182	184	2
2	Төрийн өмчит үйлдвэрийн газар	4	4	0
3	Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани	0	0	0
4	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага		0	
5	Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч	11	11	0
	Нийт	197	199	2

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 2 илүү бүртгэлтэй байгаа нь аймгийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба бүтцийн өөрчлөлтөөр

¹ 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар;

3.1.3.хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;

3.1.4.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;

3.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч

өөр байгууллагад нэгдсэнийг хасалт хийгээгүй, аймгийн Нийгмийн даатгалын сангийн огт ашиглалтгүй нэг хэрэглэгч бүртгэлтэй байгаагаас бүртгэсэн байгууллагын тоо илүү харагдаж байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т¹ заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн системд цахим хуудас нээлгээгүй байна. Үүнд:

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан журмын 5.1-т² заасны дагуу улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэгч аж ахуй нэгж, байгууллагуудыг шилэн дансны цахим хуудсанд бүртгэж, цахим хуудас нээх ажил хийгдээгүй байна.

Үүний улмаас дээрх 145 аж ахуйн нэгж байгууллагын шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажил орхигджээ.

Харин хуулийн 3.1.5-д¹ заасан байгууллагууд (хувийн сургууль, цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төв) -ыг бүртгэн шилэн дансны цахим хуудсанд цэс нээж, хуулийн үйлчлэлд бүрэн хамруулсан байна.

1.2 Зарим байгууллагуудын шилэн дансны мэдээлэл хүргэх цэс хууль, журамд заасан шалгуурийг хангаагүй харилцан адилгүй байна.

Дорноговь аймагт шилэн дансны нэгдсэн системд бүртгэлтэй 197 байгууллага байгаагаас аудитад 173 байгууллагыг хамруулсан. Өмнөх аудитаар зөрчил дутагдал багатай шалгагдсан 23 байгууллага болон аймаг дахь Төрийн аудитын газрыг аудитад хамруулаагүй болно.

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлд “байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх, мөн орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заасан.

Үүний дагуу аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн ЗДТГазар, Сайншанд, Замын-Үүд сумын ЗДТГазар шилэн дансны мэдээллийг байгууллагын цахим хуудсаараа дамжуулан мэдээлсэн байна. Сайншанд сумын ЗДТГазар байгууллагын цахим хуудсандаа харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээллийг холбож өгсөн байна.

Аудитаар Замын-Үүд суманд ажиллаж бусад сумдад очоогүй тул шилэн дансны мэдээллийг мэдээллийн самбараар дамжуулан хүргэсэн эсэхийг шалгах боломжгүй байв. Харин аймгийн ЗДТГ болон Сайншанд, Замын-Үүд сумдын ЗДТГазар шилэн дансны мэдээллийг мэдээллийн самбараар дамжуулан иргэд олон нийтэд хүргэж байна.

Аудитад хамрагдсан Дорноговь АЗЗА ТӨХК, Замын-Үүд сумын Борхойн наран өрхийн эрүүл мэндийн төв, Үлэмжтэнгэр /Шилэн дансны цахим системд Эхлэл гэх нэрээр орсон/ хувийн сургуулийн шилэн дансны мэдээлэл хүргэх цэс хуульд заасан шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал Дорноговь АЗЗА ТӨХК-ийн цахим хуудас нь төрийн өмчит байгууллагын зорилтот түвшин, 5 саяас дээш дүнтэй орлого зарлагын гүйлгээ,

² 5.1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн талаарх улирал бүрийн мэдээллийг дараа сарын 15-ны дотор энэ журмын 19 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар мэдээлнэ.

худалдан авалт, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт зэргийг мэдээлэх цэсгүй байна.

Борхойн наран ӨЭМТөв болон Үлэмжтэнгэр хувийн сургуулийн хувьд мэдээллийг хүргэх цэс нь төрийн өмчийн байгууллагынхтай ижил байна.

Мөн Замын-Үүд сумын 3 дугаар цэцэрлэг, ЕБ-ын 3-р сургуулийн жилийн батлагдсан төсөв хэрэглэгчийн эрхээр ороход байхгүй байгаа тул уг мэдээллийг мэдээлж чадахгүй явж ирсэн байна.

Энэ нь шилэн дансны мэдээллийг хүргэх хэлбэр, цэсэнд тохиргоо зохицуулалт хийх нэгдсэн админы хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

БҮЛЭГ 2

Төсөвт байгууллагууд шилэн дансны мэдээллийг байршуулж хэвшсэн ч төсвийн хөрөнгөөр ТАХ-г гүйцэтгэгч компаниуд уг ажлыг орхигдуулж байна.

2.1 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны системд мэдээллийг тогтмол байршуулахгүй байх зөрчил гарсаар байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-6.3 дэх хэсэгт заасан мэдээллийг хуулийн хугацаанд тогтмол мэдээлэхээр заасан.

Мөн Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-аар шилэн дансанд мэдээлэл тавихтай холбогдох харилцаа хамаарлыг зохицуулж өгсөн.

Шилэн дансны цахим хуудсанд хуулийн этгээдийн болон төсвийн захирагчийн ангиллаас хамааран жилд 1 байгууллага 99-148 мэдээллийг мэдээлэхээр байна.

Аудитад хамрагдсан төрийн болон орон нутгийн өмчит ААНБ, эрх бүхий албан тушаалтан, төрийн өмчит үйлдвэрийн газар зэрэг нийт 167 хуулийн этгээдийн мэдээлэх нийт 19906 мэдээллийн 76.4 хувь буюу 15210 мэдээллийн хугацаанд, 19.7 хувь буюу 3912 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн нийт мэдээлвэл зохих мэдээллийн 3.9 хувь буюу 784 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд огт мэдээлээгүй байна.

Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шилэн дансанд мэдээлэл байршуулсан байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. /Хүснэгт №1/

Хуулийн этгээдийн ангилал	Байгууллагын тоо	Байршуулах мэдээллийн тоо	Хугацаандаа байршуулсан мэдээллийн тоо	Хугацаа хоцорч байршуулсан мэдээллийн тоо	Огт байршуулаагүй мэдээллийн тоо
Төрийн болон орон нутгийн өмчит байгууллага	163	19540	15010	3756	774
Төрийн өмчит үйлдвэрийн газар	4	366	200	156	10
Нийт дүн	167	19906	15210	3912	784

Аудитад хамрагдсан байгууллагууд шилэн дансанд тогтмол мэдээлэх тухайн жилийн төсөв, ОНХС болон ХАА-ны төлөвлөгөө, сар бүрийн төсвийн гүйцэтгэл зэрэг мэдээллийн хугацаа хоцроосныг эс тооцвол 95 хувь мэдээлсэн байна.

Харин тогтсон хугацаанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроох, огт мэдээлэхгүй тохиолдол гарсан байна.

- Дараа жилийн төсвийн төсөл
- Санхүүгийн тайлан /хагас жил/
- Санхүүгийн тайлан /жилийн эцсийн/
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хэрэжүүлсэн арга хэмжээний тайлан
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт
- Төсвийн хэтрэлт хэмнэлт, түүний шалтгааны тайлбар

Тогтсон хугацаанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроосон, мэдээлэхгүй байх нь дараах нөхцөл байдлаас үүсдэг байна. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах албан тушаалтан нь холбогдох хууль, журмын талаарх мэдлэг хангалтгүй байдаг,
- Зарим байгууллага, албан тушаалтан шилэн дансны цахим хуудасны өөрийн байгууллагад хамааралгүй мэдээллийн төрлийг мэдээлдэггүй,
- Мэдээлэл байршуулах эрх бүхий албан тушаалтан солигдсон,
- Мэдээллийг дутуу оруулах, нөхөж оруулах
- Сүлжээний доголдол үүсэх,
- Ажилтны хариуцлагагүй байдалтай холбоотой байна.


Цаашид төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, түүний эд хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан хугацаа хоцорсон болон байршуулаагүй мэдээллийг тогтсон хугацаанд мэдээлж байх шаардагатай байна.

Дээрх огт мэдээлээгүй 784 мэдээллийг нөхөн байршуулах талаар зөвлөмж өгч, аудитын явцад залруулж ажиллалаа.

2.2 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд 7 хоногийн дотор мэдээлэх мэдээллийн 71.5 хувийг хугацаанд нь мэдээлжээ.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасан мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлэхээр заасан.

Аудитад хамрагдсан төрийн болон орон нутгийн өмчийн 163 байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар 4 нийт 167 хуулийн этгээдийн тухай бүр мэдээлэх 7191 мэдээллээс 6352 мэдээллийг байршуулж, 9.5 тэрбум төгрөгийн 839 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдлыг графикаар харуулав.



Дээрх шилэн дансны цахим хуудсанд байршуулж мэдээлээгүй нийт 5.2 тэрбум төгрөгийн 490 ажил гүйлгээг аудитын явцад залруулав.

2.5 Төсвийн хөрөнгөөр ТАХ-г гүйцэтгэгч хуулийн этгээдүүд Шилэн дансны цахим системд мэдээллийг байршуулах ажлыг огт хийхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэгт заасан мэдээллийг журмын дагуу мэдээлэхээр заасан.

Аймаг, сумдын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэгч ААНБ, иргэн давхар өөрийн цэсэнд мэдээлэхээр хуулинд заасан ч хуулийн энэ заалт хэрэгжихгүй байна.

Учир нь гүйцэтгэгч ААНБ-уудаас мэдээллээ оруулахыг шаардаж, оруулсан мэдээлэлд хяналт тавих албан тушаалтан байхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д заасан байгууллагууд буюу төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээ гүйцэтгэгч нийт 6 байгууллага (хувийн сургууль, цэцэрлэг, МСҮТ) байна. Эдгээр байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд цэс нээлгэн, мэдээллийг байршуулж ажиллаж байна.

Дээрх байгууллагууд тогтсон хугацаанд мэдээлэх 234 мэдээллийн 60 мэдээллийг хугацаанд нь, 169 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Мэдээллийг хугацаанд нь мэдээлэх үйл явц 25 хувьтай байна.

3.1 Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурал хуулиар олгогдсон хөндлөнгийн хяналтын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8.1-д энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ гэж заасан байна.

Аймгийн ИТХ-аас 2017 оны 05 дугаар сард ЗДТГ-ын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Татварын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, аймгийн ГХБХБГазар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлсэн байдалд хяналт, шалгалт хийсэн байна. Уг шалгалтаар илэрсэн зөрчилд холбогдох зөвлөмжүүдийг өгч, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн СТСХэлтэст үүрэг болгосон байна.

Аймгийн ИТХ-аас гадна сумдын ИТХ тухайн хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахаар хуульчилж өгсөн байдаг. Үүний дагуу 14 сумын ИТХ-аас хэрэгжүүлсэн хяналтын талаарх тайлан мэдээг авахад 10 сумын ИТХ хөндлөнгийн хяналт тавьж ажилласан. Айраг, Хатанбулаг, Дэлгэрэх, Улаанбадрах сумын ИТХ уг хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаагүй бөгөөд тайлант онд хяналтыг хэрэгжүүлэх талаар тайлбар ирүүлсэн.

Сумдын ИТХ-аас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Сайншанд, Алтанширээ, Өргөн, Иххэт сумдын ИТХ сар бүр тогтмол,
- Даланжаргалан, Мандах, Эрдэнэ, Хөвсгөл сумдын ИТХ аудитад хамрагдсан хугацаанд нэг удаа,
- Замын-Үүд, Сайхандулаан сумын ИТХ зарим төсөвт байгууллагад хяналт тавьж ажилласан.

Дээрх хяналт шалгалтаар дараах алдаа дутагдал илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хугацаа хоцроож байршуулах,
- Цахим хуудаст мэдээллийг оруулсан боловч баталгаажуулалт /зөвхөн мэдээллийг хадгалсан/ хийхгүй байх,
- Хөрөнгө зарцуулах тушаал, шийдвэрийг дутуу байршуулах,
- Удирдлагын талаарх мэдээлэлд өөрчлөлт хийхгүй байх,

- Тайлан мэдээний тоон үзүүлэлтийг зөрүүтэй оруулах зэрэг зөрчлүүд илэрсэн байна

Илэрсэн зөрчлийг арилгах талаар тухайн байгууллагын удирдлага болон нягтлан бодогч нарт үүрэг өгч байсан ба хэрэгжилтийг тухай бүр хангуулж ажилласан байна.

Сайншанд сумын ИТХ-аас тус сумын төсөвт байгууллагын хэмжээнд 2017 оны эхний хагас жилийн байдлаар Шилэн дансны тухай хууль “хангалттай” хэрэгжсэн гэсэн үнэлгээг өгсөн байна. Даланжаргалан, Мандах, Эрдэнэ, Хөвсгөл сумдын ИТХ шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг тайлант оны 12 дугаар сард хэлэлцэхээр төлөвлөсөн байна.

3.2. Аймгийн ТЕЗ дотоод аудитын албаны өгсөн зөвлөмжийн дагуу албан тушаалтнуудад хариуцлага тооцоогүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг төсвийн Ерөнхийлөн захирагч хэрэгжүүлэхээр заасан байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих дотоод хяналтын албатай байхаар заажээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас төсвийн Ерөнхийлөн захирагчийн болон Улсын төсвийн байгууллагуудын 2016 он, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн эсэхэд хяналт, шалгалт хийсэн байна.

Хяналт шалгалтанд 2017 оны 3 дугаар улирлын байдлаар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны нийт 146 төсвийн байгууллагыг хамруулсан бөгөөд шалгалтын дүнгээс харахад нийт 14370 мэдээллийг цахим хуудсанд байршуулахаас 11044 мэдээллийг хугацаанд нь, 2344 мэдээллийг хугацаа хоцроож, 982 мэдээллийг огт мэдээллээгүй зөрчлийг илрүүлсэн байна.

Дээрх зөрчилд Санхүүгийн хяналт, аудитын албанаас Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасны дагуу хугацаа хоцроосон 31 байгууллагын төсвийн шууд захирагч нарт сануулах арга хэмжээ, 13 байгууллагын шууд захирагч нарт цалингийн хувиар тооцож сахилгын шийтгэл ногдуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Мөн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2016 онд хийсэн шалгалтыг дүнгээр Шилэн дансны тухай хуулийн бүрэн хэрэгжүүлж ажиллагүй албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцуулах саналыг аймгийн Засаг даргад 2017 оны 01 дүгээр сард хүргүүлсэн боловч уг саналын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхойгүй байна.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 13 сумдын 91 төсвийн байгууллагын шилэн дансны цахим хуудасны хэрэгжилтэнд дотоод хяналтыг хийж гүйцэтгэсэн байна.

Шалгалтын дүнгээс харахад байгууллагууд нь санхүүгийн тайлан, төсвийн төсөл, аудитын дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг байршуулдаггүй, хөрөнгө зарцуулах тушаал шийдвэрийг дутуу мэдээлдэг зөрчлүүд илэрсэн байна.

Дээрхи алдаа, зөрчлийн мөрөөр мэдээллийг нөхөн байршуулах үүрэг өгч ажиллсан байна.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан журмын 8.1-т “шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр ТЕЗ-ийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор илгээнэ” гэж заасан.

Аудитын явцад шилэн дансны хөндлөнгийн аудитын эрхээр орж улирлын тайлан илгээсэн эсэхийг шалгахад аймгийн ТЕЗ-ийн харьяа 132 байгууллагаас Сайншанд сумын 1, Замын-Үүд сумын 3 байгууллага улирлын тайланг тухай бүрт илгээсэн байна. Бусад 128 байгууллага шилэн дансны системд байгууллагын админы эрхээр нэвтэрч улирлын тайланг дотоод аудитын албанд илгээх ажлыг огт хийгээгүй байна.

Зарим байгууллагын мэдээлэл оруулах хэрэглэгч /нягтлан бодогч/ нар байгууллагын админы эрх гэж байдаг болон ямар хүн уг эрхийг эзэмшиж байгааг мэдэхгүй байна. Үүний улмаас дарга, нягтлан бодогч солигдсон тохиолдолд шилэн дансны мэдээлэл өгөх ажилтны овог нэр, утсыг шинэчлээгүй, дотоод аудитын албанд тайлан илгээгүй зөрчлүүд гарч байна.

3.3. Байгууллага, албан тушаалтны үр дүнгийн гэрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тусган дүгнэж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалтгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгохоор заасан байна.


Аудит хамрагдсан нийт 173 байгууллагаас 172 байгууллагын даргын 2016 болон 2017 онд байгуулсан үр дүнгийн гэрээтэй танилцахад 139 байгууллагын төсвийн шууд захирагчдын үр дүнгийн гэрээнд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах талаар тусгасан байна. Үр дүнгийн гэрээний уг заалтыг 2016 оны жилийн эцсийн болон 2017 оны эхний хагас жилийн ажлын тайланд тусгаж, дүгнүүлсэн байна.

Ажлын үр дүн гэрээнд шилэн дансны хөтлөлтийн талаар тусгаагүй нийт 33 байгууллага байна. Үүнд:

- Төрийн ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэгч 6 ААН /хувийн цэцэрлэг, сургууль, МСҮТ/,
- Улсын төсвийн 6 байгууллага
- Орон нутгийн болон тусгай шилжүүлэгийн төсвийн 18 байгууллага байна.

Төрийн болон орон нутгийн өмчит нийт 163 байгууллагаас 85.3 хувь нь үр дүнгийн гэрээндээ тусган, 14.7 хувь тусгаагүй байна.

График 1: Төрийн олон орон нутгийн өмчийн байгууллагын үр дүнгийн гэрээнд тусгагдсан байдал



Аудитын явцад шилэн дансны хөтлөлтийн талаар байгууллагын даргын дээд шатны байгууллагатай хийсэн үр дүнгийн гэрээнд тусгасан байдлаас гадна, нягтлан бодогчдын ажлын төлөвлөгөө, түүний биелэлтийн тайлан мэдээнд тусгасан байдалд аудит хийв. Аудитад хамрагдсан зарим байгууллагын нягтлан бодогчид Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх талаар ажлын төлөвлөгөө, тайланд тусгаж, дүгнүүлж ажилласан байв.

3.4. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд үндэслэн иргэдийн хяналтыг тодорхойлох боломжгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д хуулийн хэрэгжилтийн явц, шилэн дансны мэдээллийн зөрчил, дутагдал болон шаардлагыг байгууллага албан тушаалтан хүлээн авахгүй бол энэ талаарх гомдол мэдээллийг иргэн, хуулийн этгээд ... төрийн аудитын байгууллагад гаргах... гэж заасан байна.

Иргэд, ААНБ-аас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллага, албан тушаалтанд гаргасан эсэхийг тухайн байгууллагад хандаж, шалгахад аудитад хамрагдсан хугацаанд ирүүлсэн гомдол, санал байхгүй байв.

Мөн аудитад хамрагдсан хугацаанд иргэд, ААНБ-аас уг хуулийн хэрэгжилтийн талаарх санал, гомдлыг тус аймгийн Төрийн аудитын газарт гаргаагүй.

Иргэдийн шилэн дансны цахим хуудсанд хандаж, мэдээлэл авч байгааг хөндлөнгийн аудитын эрхээр нэвтэрч хянаж үзэхэд тус цахим системийн хандалтын тоог мэдэх боломжгүй байв.

ААНБ, иргэдээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой санал, гомдлыг олон нийтийн цахим сүлжээ болох Засгийн газрын <https://11-11.mn/>, Дорноговь аймгийн www.dornogovi.gov.mn сайтад ирүүлээгүй байна.

Хуулийн этгээд, иргэдийн санал, гомдолд үндэслэн иргэд, ААНБ-аас уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллийг ашиглаж байгааг тогтоох боломжгүй байна.

БҮЛЭГ 4

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.1 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн ч мэдээллийг байршуулахгүй байх зөрчил давтагдсаар байна.

Аймгийн Төрийн аудитын газраас “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитыг 2016 оны 12 дугаар сард дахин гүйцэтгэсэн бөгөөд аудитаар санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ, өмч хөрөнгө зарцуулах тушаал шийдвэр зэргийг нөхөн байршуулахтай холбоотой 68 албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

Албан шаардлагын хэрэгжилт 100 хувьтай байгаа ч 33 албан шаардлага хугацаандаа хэрэгжиж, 35 албан шаардлагыг хугацаа хоцроож хэрэгжүүлсэн байна.

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлж байгаа ч өмнөх аудитаар албан шаардлага авсан байгууллагууд мэдээллийг хугацаа хоцроож мэдээлэх, огт мэдээлэхгүй байх зэрэг зөрчлүүдийг давтан гаргасаар байна.

Тухайлбал: Сайншанд дахь Гаалийн газар, Зүүнбаян багийн тохижилтийн алба, Сайншанд сумын 1 дүгээр сургууль, 5 дугаар сургууль, Дэлгэрэх сумын орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагууд, Иххэт сумын ЕБС, цэцэрлэг, “Эм эргэлтийн сан” ОНӨ ААТҮГ газар зэрэг байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, төсөв өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгийн орлого, зарлагыг дутуу мэдээлсэн байна.

4.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Өмнөх аудитаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга болон Засаг даргад дараах 2 зөвлөмжийг өгсөн. Үүнд:

Аймгийн ИТХ-д: Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийн хариуг 2017 оны 10 сарын 31-ний 295 тоот албан бичгээр ирүүлсэн бөгөөд дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

Аймгийн ИТХ-аас аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн хяналт, аудитын албанд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон байна.

Үүний дагуу СТСХэлтсээс 2017 оны 10 дугаар сард ТЕЗ-ийн харъяаны 13 сумын 91 байгууллагад, СХААлба 146 байгууллагыг хамруулан хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчилд холбогдох зөвлөмжийг өгч ажиллажээ.

Харин багийн Иргэдийн нийтийн хурлаас шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй бөгөөд энэ нь ажиллах нөхцөл бололцоо, хяналт хэрэгжүүлэх чадавх дутмаг байгаатай холбоотой байна.

Аймгийн Засаг даргад: *Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.*

Зөвлөмжийн хэрэгжилтийн хариуг аймгийн Засаг даргын 2017 оны 10 сарын 20-ний өдрийн 1/1886 тоот албан бичгээр ирүүлжээ. Аймгийн Засаг дарга сумын Засаг дарга, агентлагийн дарга нарын 2017 оны үр дүнгийн гэрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх заалтыг тусгасан байна.

Мөн шилэн дансны бүртгэл хөтлөлтийг сайжруулах, хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах талаар дараах ажлыг зохион байгуулсан байна.

- 2017 оны 2 дугаар сард бүх сумдын ЕБС-ийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт “Шилэн дансны тухай хууль”-ийн сургалт,
- 2017 оны 9 дүгээр сард “Санхүүгийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэн ажиллах тухай” сургалт,
- Аймгийн төсвийн ил тод байдлыг хангах ажлын удирдамж боловсруулан түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан,
- “Хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах тухай” удирдамжийн хүрээнд бүх сумдын төсөвт байгууллагын шилэн дансны мэдээллийг байршуулах үйл ажиллагааг хянаж, илэрсэн зөрчлийг арилгах үүрэг даалгавар өгсөн байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Төсвийн байгууллага, орон нутгийн болон төрийн өмчит компаниудын шилэн дансны цэс харилцан адилгүй мэдээлэл агуулсан, зарим байгууллагад оруулбал зохих мэдээллийн цэс байхгүй байна. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, стандартыг тогтоох журам”-ын 7.2.12-т “нэгдсэн админ хуульд заасан мэдээллийн төрлүүдийг бүлэглэн шилэн дансны цахим хуудсанд тохируулах” гэсэн заалтыг хангалтгүй хэрэгжүүлж байна.
2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд тогтмол мэдээлэх мэдээллийн 3.9 хувийг огт мэдээлээгүй байна.
3. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд 7 хоногийн дотор мэдээлэх мэдээллийн 28.5 хувийг хугацаанд нь мэдээлээгүй байна.
4. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагын админууд улирлын тайлан илгээх, дотоод аудитын алба шилэн дансны нэгдсэн системээр улирлын тайлан хүлээн авч хяналт тавих ажил хийгдэхгүй байна.
5. Шилэн данс хариуцсан админ, хэрэглэгч солигдсон тохиолдолд шилэн дансны системд нэвтрэх нэр, нууц үгийг өөрчлөх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажил орхигдсон байна.
6. Хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу холбогдох байгууллагууд хяналт шалгалт хийсэн боловч, алдаа зөрчлийг барагдуулах шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхойгүй байна.
7. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн барагдуулсан байна.

Аудитаар нийт 1628 мэдээллийг байршуулаагүй зөрчлийг илрүүлж, аудитын явцад 1274 мэдээллийг нөхөн байршуулах зөвлөмж, 2 албан шаардлага өгч залрууллаа.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Утас: (705) 2-30-09, факс: (705) 2-31-40,
E-mail: dornogobi.ith@gmail.com

2017.11.17 № 323
танай 2017.11.16 -ны № 1-6/724 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Ч.АРИУНАА ТАНАА

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ирүүлсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудит хийж гүйцэтгэсэн тайлантай танилцлаа. Тухайн тайлантай холбоотой санал байхгүй болно.

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА  Н.ХОНГОРЗУЛ



0000351

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Утас/факс: (705) 2-30-03

E-mail: domogobi_mgl@yahoo.com

2017.11.17 № 31/2095

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ч.АРИУНАА ТАНАА

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайланд тусгах санал үгүй.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллах болно.

ДАРГА

Б.ГАНЗОРИГ



СЗ 2467

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА

44105 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-00-26

2017.11.17 № 260
танай 2017.11.16 -ны № 1-6/722 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ч.АРИУНАА ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудит хийж гүйцэтгэсэн тайлангийн төсөлтэй танилцаж дараахь тайлбар, саналыг хүргүүлж байна. Үүнд:

1.2017 оны 10 дугаар сард ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын “Шилэн дансны хууль”-ийн хэрэгжилтэнд шалгалт хийж, шилэн дансны сайтад удаа дараа хугацаа хоцроодог, мэдээллийг огт байршуулаагүй байгууллагуудад хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ тооцуулах саналыг аймгийн Засаг даргад албан бичгээр хүргүүлсэн боловч ямар арга хэмжээ авсан талаар хариу ирүүлээгүй байна.

2. МУ-ын Сангийн яамнаас Шилэн дансны нэгдсэн системээр улирлын тайлан хүлээн авах ажлыг нэгдсэн бодлогоор хангаж ажиллаагүй байгаа бөгөөд манай байгууллага ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын Шилэн дансны хэрэгжилтийг сар тутам хяналт тавьж, зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласнаар хуулийн хэрэгжилт 93,1 хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

3.МУ-ын “Шилэн дансны тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1-д: “Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинэ байдлыг харгалзан түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулна” гэсэн байхад Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд “Төрийн эсхлэнх албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах” гэж заажээ.

Гэтэл Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулж байгаа ажилтнуудын дийлэнхи нь төрийн үйлчилгээний албан хаагчид байх ба хууль зөрчсөн ажилтнуудад тус хуулийн дагуу хариуцлага тооцуулахад дээрхи заалт нийцэхгүй байгаа тул энэ талаар бодлогын зохицуулалт хийх, мөн МУ-ын Сангийн яамнаас Шилэн дансны нэгдсэн системээр улирлын тайлан хүлээн авах ажлыг нэгдсэн бодлого, арга зүйгээр хангуулах талаар Сангийн яаманд уламжлах саналыг хүргүүлж байна.

ДАРГА



Х.ОЮУНТУЯА

000069

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Санхүүгийн хяналт аудитын албаны дарга Х.Оюунтуяа танаа:

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагын админуудыг улирлын тайлан илгээж хэвшүүлэх, илгээсэн тайланг шилэн дансны нэгдсэн системээр хүлээн авч хяналт тавих ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ц.Содхүү танаа:

Шилэн данс хариуцсан байгууллагын админ, мэдээлэл оруулах хэрэглэгч нарын нэвтрэх эрх, нууц үгийг бүртгэсэн бүртгэл бий болгож нууцлан хадгалах, хариуцсан ажилтнууд солигдсон тухай бүрт нууц үгийг өөрчлөх арга хэмжээ авах

Үндэсний аудитын газарт уламжлах санал:

Бүх төрийн байгууллага, орон нутгийн болон төрийн өмчит компаниуд, төрийн чиг үүрэгт хамаарах байгууллагуудын цэсийг өмчийн хэлбэрийн дагуу зөв бүлэглэн ангилахыг Сангийн яамны нэгдсэн админд зөвлөх

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 4/19

Дорноговь аймаг, Сайншанд сум

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 04 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйл, Ерөнхий аудиторын 2017 оны А/188 тоот тушаалын V хавсралтын 2.4, “Нийцлийн аудитын түр журам”-ын 09 дүгээр зүйлийн 03 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөө, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитын тайлан болон албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга болон Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга нарт тус тус зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Санхүүгийн хяналт, аудитын албанд тус тус хүргүүлсүгэй.

4. Зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ч.Хэрлэнчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

0825255

Дарга, тэргүүлэх аудиторын 2017 оны
11 дүгээр сарын 14-ны өдрийн
А/аг тоот тушаалын хавсралт

"Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт" сэдэвт нийцлийн аудитын албан шаардлага

№	Аудитын код	Албан шаардлагын		Хариуцах байгууллагын нэр	Товч агуулга	Дүн /төг/
		Огноо	Дугаар			
1	ҮАГ-НАГ/2017/03-НА-ДГА	2017.10.30	01/53	Аймгийн Шүүхийн тамгын газар	Мэдээлэл байршуулах тухай	0
2	ҮАГ-НАГ/2017/03-НА-ДГА	2017.10.30	02/54	Дорноговь АЗЗА ТӨҮГ	Мэдээлэл байршуулах тухай	0

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар

НИЙЦЛИЙН АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:

ГҮЙЦЭТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Л.АВААДОРЖ

АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

АУДИТОР

Б.ТУНГАЛАГТУЯА

АУДИТОР

О.НАРАНГАРАВ

АУДИТОР

У.ОЮУНТҮЛХҮҮР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ч.ХЭРЛЭНЧИМЭГ

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД

ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЬЕ.